

“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03-р дугаар сарын 20

№ 03

Улаанбаатар хот

Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дах хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, “Тээвэр ачлал” ХК (“Компани” гэх)-н Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ийг 2024 оны 04 дугаар сарын 29-ны өдрийн 15:00 цагт компанийн өөрийн байранд хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04-р сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж-д 2024 оны 03-р сарын 21-ны өдрийн дотор шаардлагатай баримт бичгийн хамт тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонинд 2024 оны 03-р сарын 21-ны өдрийн дотор нийтэд мэдээлсүгэй.
5. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хурлаар хэлцэх асуудал
 - 1) Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн тухай
 - 2) Ногдол ашиг тараахгүй болсон тухай
 - 3) Бусад

ТУЗ-ИЙН ДАРГА



/Б.БАТЗОРИГ/